



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/188-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-19
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	21-23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОУБ	Олон улсын байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг Цагаан эрэг Сүхбаатар сум
Сэлэнгэ аймаг 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНГЭРЭЛ ТАНАА

2025.02.25 № 001-2025/138-11-011-011

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 20,609.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	238,590,671.83	329,984,962.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	190,085,605.01	280,144,221.44
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	190,085,605.01	280,144,221.44
31210	Төгрөг	190,085,605.01	280,144,221.44
31211	Төрийн сангийн харилцах	190,085,605.01	280,144,221.44
33	АВЛАГА	0.00	805,440.30
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	805,440.30
35	БАРАА МАТЕРИАЛ	48,505,066.82	49,035,300.32
351	Түүхий эд материал	3,566,283.00	3,947,246.90
3511	Тусгай зориулалттай материал	3,462,983.00	3,823,691.90
3513	Эм боох материал	103,300.00	123,555.00
35400	Хангамжийн материал	44,938,783.82	45,088,053.42
3542	Аж ахуйн материал	433,395.00	1,008,996.00
3544	Түлш, шатах тослох материал	8,000.40	0.00
3546	Хүнсний материал	2,116,990.00	1,698,659.00
3547	Бусад хангамжийн материал	42,380,398.42	42,380,398.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,495,257,847.69	4,627,359,267.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,495,257,847.69	4,627,359,267.53
39200	Биет хөрөнгө	4,483,924,514.21	4,594,464,933.99
39201*	Барилга, байгууламж, орон сууц	4,414,685,944.00	4,596,872,685.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(417,953,968.52)	(528,321,116.84)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	368,104,141.17	491,575,691.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,876,219.35)	(170,857,510.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	292,478,445.87	319,118,445.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(72,596,211.51)	(133,721,543.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,997,000.00	14,112,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,997,600.24)	(8,396,700.76)
39217	Ном	14,082,982.79	14,082,982.79
39300	Биет бус хөрөнгө	11,333,333.48	32,894,333.54
39301	Програм хангамж	2,180,000.00	2,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,846,666.52)	(2,221,666.46)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,000,000.00	32,936,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,733,848,519.52	4,957,344,229.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,733,848,519.52	4,957,344,229.59

51	Засгийн газрын хувь оролцоо	4,733,848,519.52	4,957,344,229.59
51100	Засгийн газрын оруулсан капитал	11,000,000.00	32,936,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,722,848,519.52	4,924,408,229.59
51210	Өмнөх үеийн үр дүн	4,722,848,519.52	4,722,848,519.52
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	201,559,710.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,733,848,519.52	4,957,344,229.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,832,520,895.38	3,689,090,409.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	636,297,595.38	283,691,166.00
120	Нийтлэг татварын бус орлого	332,552,411.50	283,691,166.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,805,688.00	21,936,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,275,688.00	19,346,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,530,000.00	2,590,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	282,865,034.00	261,754,866.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	35,881,689.50	0.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	303,745,183.88	0.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	303,745,183.88	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,196,223,300.00	3,405,399,243.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,196,223,300.00	3,111,114,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,196,223,300.00	3,111,114,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	19,024,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	19,024,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	275,260,443.11

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	275,260,443.11
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,402,989,235.91	3,487,530,699.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,402,989,235.91	3,487,530,699.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,277,238,896.71	3,357,588,248.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,579,231,201.05	2,371,529,785.06
210101	Үндсэн цалин	1,077,964,371.36	1,387,569,507.64
210102	Нэмэгдэл	450,186,223.76	903,487,147.02
210103	Урамшуулал	51,080,605.93	80,473,130.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	197,710,510.31	292,982,872.76
210201	Тэтгэврийн даатгал	131,617,410.31	193,847,113.11
210202	Тэтгэмжийн даатгал	16,523,200.00	24,809,760.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,218,800.00	12,404,830.36
210204	Ажилгүйдлийн даатгал	3,304,700.00	12,384,193.72
210205	Эрүүл мэндийн даатгал	33,046,400.00	49,536,974.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,833,852.64	266,474,743.11
210301	Гэрэл, цахилгаан	17,853,907.61	18,581,741.76
210302	Түлш, халаалт	195,372,585.02	207,851,138.01
210303	Цэвэр, бохир ус	39,607,360.01	40,041,863.34
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	34,777,778.90	35,220,991.00
210502	Хоол, хүнс	34,777,778.90	35,220,991.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,462,340.00	11,369,600.00
210604	Урсгал засвар	31,462,340.00	11,369,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,078,943.27	53,402,719.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,514,700.00	9,247,502.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,564,243.27	44,155,217.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,144,270.54	326,607,537.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,514,840.00	77,248,076.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,637,900.00	21,111,590.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,991,530.54	228,247,871.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,750,339.20	129,942,450.10

2132	Бусад урсгал шилжүүлэг	125,750,339.20	129,942,450.10
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	107,894,739.20	116,546,450.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,855,600.00	13,396,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	429,531,659.47	201,559,710.07
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	30,410,770.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	399,120,889.47	201,559,710.07

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,513,774,171.88	3,427,335,543.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,550,871.88	21,936,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,805,688.00	21,936,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,805,688.00	21,936,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,275,688.00	19,346,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,530,000.00	2,590,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	303,745,183.88	0.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	303,745,183.88	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,196,223,300.00	3,405,399,243.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,196,223,300.00	3,111,114,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,196,223,300.00	3,111,114,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	19,024,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	19,024,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	275,260,443.11
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	275,260,443.11
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,331,929,617.54	3,260,618,501.68

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,331,929,617.54	3,260,618,501.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,206,248,641.34	3,130,315,342.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,579,231,201.05	2,371,529,785.06
210101	Үндсэн цалин	1,077,964,371.36	1,387,569,507.64
210102	Нэмэгдэл	450,186,223.76	903,487,147.02
210104	Урамшуулал	51,080,605.93	80,473,130.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,734,791.34	293,788,313.06
210201	Тэтгэврийн даатгал	130,641,691.34	194,652,553.41
210202	Тэтгэмжийн даатгал	16,523,200.00	24,809,760.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,218,800.00	12,404,830.36
210204	Ажилгүйдлийн даатгал	3,304,700.00	12,384,193.72
210205	Эрүүл мэндийн даатгал	33,046,400.00	49,536,974.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,275,883.88	266,474,743.11
210301	Гэрэл, цахилгаан	17,853,907.61	18,581,741.76
210302	Түлш, халаалт	195,372,585.02	207,851,138.01
210303	Цэвэр, бохир ус	59,049,391.25	40,041,863.34
2105	Нормативт зардал	36,331,091.40	34,802,660.00
210502	Хоол, хүнс	36,331,091.40	34,802,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,469,300.00	8,785,700.00
210604	Урсгал засвар	31,469,300.00	8,785,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,078,943.27	53,402,719.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,514,700.00	9,247,502.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,564,243.27	44,155,217.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,127,430.40	101,531,421.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,489,530.40	77,492,346.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,637,900.00	24,039,075.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,680,976.20	130,303,159.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,680,976.20	130,303,159.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	107,825,376.20	116,907,159.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,855,600.00	13,396,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	181,844,554.34	166,717,041.43

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	76,596,810.00	76,658,425.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	76,596,810.00	76,658,425.00
2200	Дотоод эх үүсвэрээр	76,596,810.00	76,658,425.00
222001	Тоног төхөөрөмж	35,632,023.00	43,903,425.00
223001	Бусад хөрөнгө	40,964,787.00	32,755,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(76,596,810.00)	(76,658,425.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	105,247,744.34	90,058,616.43
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		190,085,605.01
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		280,144,221.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,000,000.00	0.00	4,722,848,519.52	4,733,848,519.52
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	21,936,000.00	0.00	0.00	21,936,000.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	201,559,710.07	201,559,710.07
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,936,000.00	0.00	4,924,408,229.59	4,957,344,229.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,669,533,468.11	3,337,276,926.68	332,256,541.43	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,592,875,043.11	3,260,618,501.68	332,256,541.43	90.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,448,719,743.11	3,130,315,342.68	318,404,400.43	90.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,553,172,700.00	2,371,529,785.06	181,642,914.94	92.9
210101	Үндсэн цалин	1,611,230,300.00	1,387,569,507.64	223,660,792.36	86.1
210102	Нэмэгдэл	885,966,200.00	903,487,147.02	(17,520,947.02)	102.0
210104	Урамшуулал	55,976,200.00	80,473,130.40	(24,496,930.40)	143.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	319,146,600.00	293,788,313.06	25,358,286.94	92.1
210201	Тэтгэврийн даатгал	217,019,700.00	194,652,553.41	22,367,146.59	89.7
210202	Тэтгэмжийн даатгал	25,531,800.00	24,809,760.71	722,039.29	97.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,765,800.00	12,404,830.36	360,969.64	97.2
210204	Ажилгүйдлийн даатгал	12,765,800.00	12,384,193.72	381,606.28	97.0
210205	Эрүүл мэндийн даатгал	51,063,500.00	49,536,974.86	1,526,525.14	97.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	266,474,743.11	266,474,743.11	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	18,581,741.76	18,581,741.76	0.00	100.0
210302	Түлш, халаалт	207,851,138.01	207,851,138.01	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	40,041,863.34	40,041,863.34	0.00	100.0
2105	Нормативт зардал	52,044,200.00	34,802,660.00	17,241,540.00	66.9
210502	Хоол, хүнс	52,044,200.00	34,802,660.00	17,241,540.00	66.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,785,700.00	8,785,700.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	8,785,700.00	8,785,700.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,227,300.00	53,402,719.53	19,824,580.47	72.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,176,700.00	9,247,502.00	(70,802.00)	100.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	64,050,600.00	44,155,217.53	19,895,382.47	68.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,868,500.00	101,531,421.92	74,337,078.08	57.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,137,400.00	77,492,346.92	73,645,053.08	51.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,731,100.00	24,039,075.00	692,025.00	97.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,155,300.00	130,303,159.00	13,852,141.00	90.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	144,155,300.00	130,303,159.00	13,852,141.00	90.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	130,759,300.00	116,907,159.00	13,852,141.00	89.4

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,396,000.00	13,396,000.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	76,658,425.00	76,658,425.00	0.00	
	Дотоод эх үүсвэрээр	76,658,425.00	76,658,425.00	0.00	
222001	Тоног төхөөрөмж	43,903,425.00	43,903,425.00	0.00	
223001	Бусад хөрөнгө	32,755,000.00	32,755,000.00	0.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,419,420,643.11	3,427,335,543.11	(7,914,900.00)	100.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,122,623,900.00	3,130,138,800.00	(7,514,900.00)	100.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,122,623,900.00	3,111,114,300.00	11,509,600.00	99.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	19,024,500.00	(19,024,500.00)	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	275,260,443.11	275,260,443.11	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,536,300.00	21,936,300.00	(400,000.00)	101.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,346,300.00	19,346,300.00	0.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,190,000.00	2,590,000.00	(400,000.00)	118.3
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		190,085,605.01	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		280,144,221.44	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь “Хүүхдийн сэтгэлийг ойлгон дэмждэг, хариуцлагатай мэдлэг чадвар ёс суртахуунаар үлгэрлэсэн хамт олон байна” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Тус байгууллага нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах,
- Сурагчдын хөгжил, төлөвшлийг хангах,
- Сургалтын үйл ажиллагаа, багшийн ажлын гүйцэтгэлд суурилан багшийн тасралтгүй хөгжлийг хангах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 223,495.7 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	190,085.6	280,144.2	90,058.6
Авлага		805.4	805.4
Бараа материал	48,505.1	49,035.3	530.2
Үндсэн хөрөнгө	4,495,257.8	4,627,359.3	132,101.5
Нийт хөрөнгө	4,733,848.5	4,957,344.2	223,495.7
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,733,848.5	4,957,344.2	223,495.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /өмчийн дүн	4,733,848.50	4,957,344.2	223,495.7

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 280,144.2 мянган төгрөг болж 90,058.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансны үлдэгдэл 805.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү шилжүүлснээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 49,035.3 мянган төгрөг болж 530.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 218,921.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж 218,391.3 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 5,470,877.8 мянган төгрөг болж 360,349.3 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 182,186.7 мянган төгрөгийн гадна фасад, 7,300.0 мянган төгрөгийн гэрлэн гарц, БЕГ-с 54,866.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, ширээ сандал, Дезерет ОУБ-с 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, тухайн байгууллагын эзэмшлийн газрыг 21,936.0 мянган төгрөгөөр үнэлэн биет бус хөрөнгөөр бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 76,658.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 228,247.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 2,295,968.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 266,504.7 мянган төгрөг, нийт 2,562,473.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 39,594.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,121.9 мянган төгрөгөөр нийт 43,716.7 мянган төгрөгөөр бууруулж, сургалт семинарын зардлыг 4,121.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,522,878.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 3,182,651.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 275,260.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 21,536.3 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 190,085.6 мянган төгрөг төвлөрүүлж, нийт **3,669,533.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийг нийт 1,146,654.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Үүнд :

- Цалин, НДШ-ийн зардлыг 939,942.1 мянган төгрөгөөр,
- Хоол хүнсний зардлыг 11,056.3 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 28,402.1 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 94,592.6 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 58,213.0 мянган төгрөгөөр,
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 14,448.7 мянган төгрөгөөр гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 3,669,533.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 3,337,276.9 мянган төгрөгийг зарцуулж 332,256.6 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,337,276.9 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь үдийн цай хөтөлбөрийн зардлыг 13,852.2 мянган төгрөгөөр, дотуур байрны зардлыг 27,934.6 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 290,469.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	6,182.8	6,182.8	-	100.0
		2	81816-Хүүхэд хамгаалал	6,568.6	6,568.6	-	100.0
		3	80312- Сургалт семинар	4,556.9	4,556.9	-	100.0
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	6,182.8	6,071.0	111.8	98.2
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	130,759.3	116,907.2	13,852.1	89.4
		6	81806- Дотуур байрны үйлчилгээ	201,925.6	173,991.0	27,934.6	86.2
		7	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	53,601.4	53,601.4	-	100.0
		8	81823- Боловсролын багшийн сургалт	18,610.0	10,234.6	8,375.4	55.0
		9	81834- Боловсролын стандарт сургалт	2,845,243.2	2,585,341.2	259,902.0	90.9
		10	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	77,756.6	75,170.2	2,586.4	96.7
		11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	21,649.5	2,599.5	19,050.0	12.0
		12	81848-Сурах бичиг	9,691.8	9,247.5	444.3	95.4
		13	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	11,509.6	11,509.6	-	100.0
		14	83603-Дээд шатны төсвөөс хувиарласан	35.0	35.0	-	100.0
		15	80111-Тогтмол зардал	275,260.4	275,260.4	-	100.0
Нийт				3,669,533.5	3,337,276.9	332,256.6	90.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 159,846.1 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 1 удаа зарласан боловч гүйцэтгэгч ирээгүй учраас хоол хүнсийг “Ноцох дөл”, “Сэлэнгэ шидэт” ХХК, “Эх наран булаг” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,433,400.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,334.0

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 162 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Байгууллагын батлагдсан төсөв -1 удаа
- Аудитын тайлан, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ-1удаа
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, төсвийн хэтрэлт, хэмнэлт-7 удаа

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар багш нарт 19,024.5 мянган төгрөгийн ур чадварын урамшууллыг давхардуулан олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлжээ.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	19,024.5	1	19,024.5	100.0
Албан шаардлага	1	26,094.6	1	26,094.6	100.0
Нийт дүн	2	45,119.1	2	45,119.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах **51,484.9** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 35,254.7 мянган төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16,230.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **6,860.4** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **6,055.0** мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, **805.4** мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгосон багш Д.Ариунсэлэнгэ, Г.Мягмарсүрэн нарын ажилласан хоногийг зөрүүтэй тооцож 1,007.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2.Тооцооллын алдаанаас шалтгаалж багш С.Өлзийжаргалын ажилласан хоногийг зөрүүтэй тооцож 124.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 20 дугаар зүйлийн 20.2 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.”*, 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч Ч.Цэндмаа, нярав С.Отгонцацрал нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 1,445.1 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь *“Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”*, 14.2.3: *“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдүүлэн олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4. Улирлын амралттай хугацаанд бус хичээлийн жил эхлээгүй байхад буюу 8 дугаар сард 31 багшийн анги даалтын нэмэгдэлд 1,985.4 мянган төгрөгийг тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар *“Журамд өөрчлөлт оруулах тухай”* тушаалын 1 дэх *“Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5. Ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүй 7 багшид 1,493.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан *“Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай”* тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь *“Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалингийн нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 805.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалингийн зардал дутуу тайлагнасан	1	35,254.7	1	35,254.7			1	35,254.7				
НДШ-ийн зардал илүү тайлагнасан	1	16,230.2			1	16,230.2	1	16,230.2				
Дүн	2	51,484.9	1	35,254.7	1	16,230.2	2	51,484.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	6,055.0	1	6,055.0								
Авлага үүсгэсэн	1	805.4			1	805.4						
Дүн	1	6,860.4	1	6,055.0	1	805.4						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим санд 9 мэдээллийг хугацаа хоцроосон	1						1	
Нийт дүн	1						1	
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.